



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2010/09
Огноо: 2010 оны 9-р сарын 23
Эмбарго: 2010 оны 9-р сарын 24-ний Баасан гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Үндэсний Статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 8 дугаар сарын байдлаар инфляци улсын хэмжээнд жилийн 11.2 хувь байна. 2010 оны эхний хагаст эрчимтэй нэмэгдэж байсан инфляцийн өсөлт 3-р улиралд буурч байна. Оны эхний хагас жилд инфляци 10.6 нэгж хувиар нэмэгдсэн бол сүүлийн 2 сард нэмэгдээгүй болно. Инфляци буурах энэ боломжийг лавшруулах, цаашид тогтворжуулахад Монголбанк илүү анхаарч ажиллах юм.

Нийт эрэлтийг ирэх 2011 оны 2 дугаар хагаст нэмэгдүүлэн эдийн засгийн тэлэлтийн боломжийг бий болгох зорилгоор бодлогын хүүг инфляцийн байдалтай уялдуулан бууруулах нь зүйтэй гэж үзлээ. Гэхдээ уг арга хэмжээг дариу хэрэгжүүлэх бололцоогүй байна.

Ирэх 10 дугаар сараас төрийн албан хаагчдын цалин нэмэгдэнэ. Орлогын энэ өсөлтийн инфляцийн нөлөөг аль болох бага байлгахад Монголбанк сүүлийн 4 сарын турш арга хэмжээ авч ажиллаа. Цалингийн энэ өсөлтийн инфляцийн нөлөө бага байх болно. Гэхдээ үнэ өсөх хүлээлт, өсгөх эрмэлзлэл нэмэгдэх боломжтой юм. Мөн түүнчлэн өнөөдрийн шийдвэр гаргаж байгаа тооцоо нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр үндэслэсэн болно. Ирэх 2011 оны төсвийн төслийг боловсруулж байгаа тул энэ үндэслэл өөрчлөгдөх боломжтой байна. Эдгээр нөхцөл байдал тодорхой болсны дараа бодлогын хүүгийн өөрчлөлтийг дахин авч үзэх болно.

МОНГОЛБАНК